

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 22/01

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 04 сарын 12-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь даатгал ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

## Санхүүгийн тайлан үйл ажиллагааны талаарх дүгнэлт

Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2021 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 1.4% гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 21.1%-аар өссөн жил боллоо.

“Бодь Даатгал” ХК –ийн хувьд 2021 онд санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай гарсан байна. Үүнд:

Цэвэр хураамжийн орлого 30% өсч 19.1 т.б (тэрбум) хүрсэн нь даатгалын салбарын нийт цэвэр хураамжийн орлогын 13.8 %-ыг эзэлж байна. (өнгөрсөн оноос +2.1% өссөн). Үүнээс гэрээний огноог 365 хоногт хувь тэнцүүлж 17.1 т.б-ыг орлогод тооцож авсан нь өнгөрсөн оны 14.8 т.б-аас 15%-иар өндөр байна. Орлогод тооцсон хураамж 15% өссөн боловч зардал тооцсон нөөц сан болон нөхөн төлбөрийн хэмжээ 30% өссөнөөр даатгалын үйл ажиллагаа алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.

Орлогод тооцсон хураамж төлөвлөсөн дүнд хүрч, давхар даатгалын шимтгэлийн орлогыг 1.6 т.б-аар давуулан биелүүлсэн боловч нөхөн төлбөрийн зардал 2 т.б-аар илүү гарснаар ашиг зорилтот үр дүнд хараахан хүрээгүй буюу 863.9 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан байна. Даатгалын гэрээний зардал 2020, 2021 онд 15% байгаа нь салбарын дунджаас 5% орчим бага байна.

### **Төлбөрийн чадварын үзүүлэлт**

Давхар даатгалын хойшлогдсон хураамж болон нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан даатгагчийн хариуцсан цэвэр хөрөнгө 29.38 т.б төгрөг байна. Үүнээс 8.88 т.б төгрөгийн хөрөнгийг зөвшөөрөгдөхгүй хөрөнгөд тооцож үлдсэн 20.49 т.б төгрөг зөвшөөрөгдөж байна. Энэ нь 15.1 т.б төгрөгийн нөөц сан, өр төлбөр болон заавал байлгах 5 т.б төгрөгийн нийлбэрээс 1.64%-иар илүү буюу төлбөрийн чадварын үзүүлэлт 101.64% гарсан байна.

### **Нөөцийн сан**

Даатгалын цэвэр хураамж болох 19.15 т.б төгрөгийн 7.93 т.б буюу 41% нь орлогод тооцогдолгүй нөөцлөгдсөн. Өнгөрсөн онд энэ харьцаа 39.8% байсан байна. Энэ нөөц дутах эрсдэлтэй бөгөөд, 45-50%-ийн хооронд хүргэх хэрэгтэй.


Төлөгдөөгүй үлдсэн байх магадлалтай замд яваа нөхөн төлбөрийн нөөц буюу Мэдсэн боловч төлөөгүй, Учирсан боловч төлөгдөөгүй нөөцүүд нийлээд 1.1 т.б байгаа нь хангалттай гэж үзэж байна. Энэ нөөц жилийн нөхөн төлбөрийн 10% орчим эзэлдэг. Хөрөнгө хариуцлага зэрэг нөхөн төлбөр удаан үргэлжлэх даатгал голчлон хийдэг компанийн хувьд өндөр байдаг.

Зардал, нөхөн төлбөрийн орлогод тооцсон хураамжаас давсан хувиар (Combined ratio, эсвэл Хосолсон харьцаа) байгуулсан Учирч болзошгүй хохирлын нөөц 1.4 т.б байна.

Компанийн цэвэр ашиг салбарынхаа 4.17%-ийг эзэлж байна.(өмнөх оныхоос -6.8%)  
ТУЗ-ын зүгээс компанийн цэвэр ашиг 0.86 т.б төгрөг гарсан нь компанийг зорилтот ашигтаа хүрээгүй дунд түвшинд ажилласан гэж дүгнэж байна.

Цаашид цар тахалтай холбоотой гадаад болон дотоодын хил гаалийн хорио арилж эдийн засаг сэргэж улмаар эдийн засгийн өсөлтийг даган даатгалын ашиг өсөх боломжтой тул даатгалын бүтээгдэхүүн нэр төрлөө нэмэгдүүлж даатгалын үйл ажиллагааг ашигтай байхаар зорьж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ТУЗ-ИЙН ДАРГЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨДӨГЧ



Б.БИЛЭГТ